

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН,ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	13
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	17
3.7 Шилэн дансны мэдээлэл	18
3.8 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	18
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	19
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	20
4. Менежментийн захидал	21
4.1 Балансын данстай холбоотой асуудал.....	21
4.2 Балансын данстай холбоотой асуудал.....	21
4.3. Худалдан авалт, гэрээний хэрэгжилтийн талаар	22
4.4. Зардлын данстай холбоотой асуудал.....	22
4.5. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал.....	22
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХШҮДАГ	Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
МЭГ	Мал эмнэлгийн газар
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори
МЭЭСБУЛ	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.03.25 № 01/1006
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Мал эмнэлгийн ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 36 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг төлөвлөн 83.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Мал эмнэлгийн ерөнхий газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн бараа материалыг шууд зардлаар бүртгэсэн, анхан шатны бүрдэл дутуу, баримтгүй зарцуулсан, эд хөрөнгийн тооллого хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй, цалин урамшууллыг буруу тооцож олгосон, авлага, өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн зэрэг 2,717.8 сая төгрөгийн алдаа зөрчлийн дүн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс их байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд, Сангийн сайдын баталсан холбогдох заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн Эрх ба үүрэг, Үнэлгээ, Үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16,084,573.3	11,883,999.7
МӨНГӨН ХӨРӨНГӨ	260.5	0.0
АВЛАГА	3,704,617.8	811,816.2
УРЬДЧИЛГАА	4,866.8	83,808.4
БАРАА МАТЕРИАЛ	12,374,828.1	10,988,375.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	18,740,851.1	26,324,447.4
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	18,740,851.1	26,324,447.4
Биет хөрөнгө	16,608,622.1	24,170,110.2
Биет бус хөрөнгө	1,832,229.0	2,154,337.2
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	34,825,424.4	38,208,447.2
НИЙТ ӨР ТӨЛБӨР	19,464.2	1,692,256.4
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,464.2	1,692,256.4
Өглөг	19,464.2	1,692,256.4
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	34,805,960.2	36,516,190.7
Засгийн газрын хувь оролцоо	34,805,960.2	36,516,190.7
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,281,790.5	9,281,790.5
Хуримтлагдсан үр дүн	21,382,692.8	23,122,784.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,141,476.9	4,111,615.5
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	34,825,424.4	38,208,447.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	101,482,831.4	62,774,778.3
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,892,699.3	9,555,727.4
Нийтлэг татварын бус орлого	32,892,699.3	9,555,727.4
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	68,590,132.1	53,219,051.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	81,224,957.0	60,916,974.0
УРСГАЛ ЗАРДАЛ	81,224,957.0	60,916,974.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	80,247,901.2	59,261,431.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,870,222.2	6,158,162.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	654,734.9	847,955.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	520,400.5	590,790.2
Хангамж, бараа материалын зардал	1,255,388.0	1,525,702.6
Нормативт зардал	34,828,370.5	22,858,728.5
Эд хогшил, урсгал засварын зардал	713,628.4	361,706.6
Томилолт, зочны зардал	351,755.2	267,127.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,040,929.6	22,319,750.3
Бараа үйлчилгээний бусад зардал	6,012,471.8	4,331,507.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	977,055.8	1,655,542.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	20,257,874.4	1,857,804.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	20,256.0	148,215.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	20,237,618.5	1,709,588.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	69,349,802.9	57,745,568.1
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	520,489.7	867,311.2
Нийтлэг татварын бус орлого	520,489.7	867,311.2
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	68,829,313.2	56,878,256.9
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	68,211,484.0	53,997,667.0
УРСГАЛ ЗАРДАЛ	68,211,484.0	53,997,667.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,590,277.1	51,723,180.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,585,509.1	4,728,216.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	452,324.1	621,017.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	539,607.4	529,823.6
Хангамж, бараа материалын зардал	1,019,787.0	893,656.7
Нормативт зардал	13,411,010.5	13,905,955.9
Эд хогшил, урсгал засварын зардал	908,244.8	1,017,534.3
Томилолт, зочны зардал	248,756.4	259,068.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,009,588.9	28,194,847.0
Бараа үйлчилгээний бусад зардал	4,315,448.8	1,510,060.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,621,206.9	2,274,484.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,138,318.9	3,747,903.1
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,139,183.7	3,748,163.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,139,183.7	3,747,903.1
Дотоод эх үүсвэрээр	1,139,183.7	3,747,903.1
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-1,139,183.7	-3,747,903.1
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-864.8	-260.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,125.2	260.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	260.5	0.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,568,341.7	0.0	14,568,341.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-2,081,107.8	0.0	-2,081,107.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,487,233.9	0.0	12,487,233.9
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,081,107.8	0.0	2,081,107.8
Тайлант үеийн үр дүн	20,237,618.5	0.0	20,237,618.5
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	34,805,960.2	0.0	34,805,960.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	30,503.4	0.0	30,503.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	34,836,463.6	0.0	34,836,463.6
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-29,861.4	0.0	-29,861.4
Тайлант үеийн үр дүн	1,709,588.5	0.0	1,709,588.5
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,516,190.7	0.0	36,516,190.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	47,143,105,900.00	44,001,287,918.11	3,141,817,981.89	93.3
УРСГАЛ ЗАРДАЛ	47,143,105,900.00	44,001,287,918.11	3,141,817,981.89	93.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,531,277,000.00	43,425,045,768.10	3,106,231,231.90	93.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,668,985,500.00	4,597,571,441.61	71,414,058.39	98.5
Үндсэн цалин	3,250,138,300.00	3,237,259,058.67	12,879,241.33	99.6
Нэмэгдэл	1,206,056,100.00	1,130,503,258.93	75,552,841.07	93.7
Унаа хоолны хөнгөлөлт	212,791,100.00	229,809,124.01	-17,018,024.01	108.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	631,838,400.00	620,393,092.30	11,445,307.70	98.2
Тэтгэврийн даатгал	450,675,000.00	439,438,537.23	11,236,462.77	97.5
Тэтгэмжийн даатгал	45,290,900.00	45,011,615.70	279,284.30	99.4
ҮОМШӨ-ний даатгал	36,232,400.00	37,120,491.01	-888,091.01	102.5
Ажилгүйдлийн даатгал	9,058,500.00	8,983,875.69	74,624.31	99.2
Эрүүл мэндийн даатгал	90,581,600.00	89,838,572.67	743,027.33	99.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	613,531,200.00	576,047,359.95	37,483,840.05	93.9
Гэрэл, цахилгаан	195,094,700.00	186,793,656.05	8,301,043.95	95.7
Түлш, халаалт	336,353,600.00	320,402,951.90	15,950,648.10	95.3
Цэвэр, бохир ус	37,149,700.00	24,840,389.00	12,309,311.00	66.9
Байрны түрээс	44,933,200.00	44,010,363.00	922,837.00	97.9
Хангамж, бараа материалын зардал	744,188,800.00	708,476,765.58	35,712,034.42	95.2
Бичиг хэрэг	171,963,500.00	160,276,937.00	11,686,563.00	93.2
Тээвэр, шатахуун	372,413,300.00	355,353,958.00	17,059,342.00	95.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	140,456,500.00	139,330,860.58	1,125,639.42	99.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,629,600.00	3,171,800.00	457,800.00	87.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	55,725,900.00	50,343,210.00	5,382,690.00	90.3
Нормативт зардал	12,144,634,700.00	12,140,959,898.38	3,674,801.62	100.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,110,946,100.00	12,107,431,334.38	3,514,765.62	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	33,688,600.00	33,528,564.00	160,036.00	99.5
Эд хогшил, урсгал засварын зардал	965,031,600.00	941,052,416.50	23,979,183.50	97.5
Багаж, техник, хэрэгсэл	546,008,900.00	528,809,141.00	17,199,759.00	96.8
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	135,458,100.00	135,083,297.00	374,803.00	99.7
Урсгал засвар	283,564,600.00	277,159,978.50	6,404,621.50	97.7
Томилолт, зочны зардал	96,135,300.00	86,037,669.00	10,097,631.00	89.5
Дотоод албан томилолт	96,135,300.00	86,037,669.00	10,097,631.00	89.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,475,833,400.00	23,567,390,988.38	2,908,442,411.62	89.0

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,328,683,400.00	23,431,764,402.60	2,896,918,997.40	89.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	20,794,800.00	19,354,500.00	1,440,300.00	93.1
Даатгалын үйлчилгээ	24,653,100.00	22,802,133.00	1,850,967.00	92.5
Тээврийн хэрэгслийн татвар	9,509,100.00	8,049,782.00	1,459,318.00	84.7
Тээврийн хэрэгслийн оношилгоо	3,839,200.00	3,055,460.00	783,740.00	79.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	80,897,800.00	77,078,048.78	3,819,751.22	95.3
Газрын төлбөр	7,456,000.00	5,286,662.00	2,169,338.00	70.9
Бараа үйлчилгээний бусад зардал	191,098,100.00	187,116,136.40	3,981,963.60	97.9
Бараа үйлчилгээний бусад зардал	189,011,400.00	185,766,136.40	3,245,263.60	98.3
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,086,700.00	1,350,000.00	736,700.00	64.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	611,828,900.00	576,242,150.01	35,586,749.99	94.2
Бусад урсгал шилжүүлэг	611,828,900.00	576,242,150.01	35,586,749.99	94.2
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,735,000.00	5,469,022.00	265,978.00	95.4
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	544,618,700.00	510,077,726.01	34,540,973.99	93.7
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	61,475,200.00	60,695,402.00	779,798.00	98.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	47,143,105,900.00	44,001,287,918.11	3,141,817,981.89	93.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	46,619,800,000.00	43,269,773,169.61	3,350,026,830.39	92.8
Улсын төсвөөс санхүүжих	46,619,800,000.00	43,269,773,169.61	3,350,026,830.39	92.8
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	523,305,900.00	731,514,748.50	-208,208,848.50	139.8
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	523,305,900.00	731,514,748.50	-208,208,848.50	139.8
БАЙГУУЛЛАГЫН ТОО	25	25	0	100.0
Төсвийн байгууллага	25	25	0	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	377	377	0	100.0
Удирдах ажилтан	5	5	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	319	319	0	100.0
Үйлчлэх ажилтан	53	53	0	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	377	377	0	100.0
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	79	79	0	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	298	298	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,793,909,932.22
УРСГАЛ ЗАРДАЛ	16,853,726,548.22
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,113,276,785.71
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130,645,430.63
Үндсэн цалин	6,715,000.00
Гэрээт ажлын хөлс	123,930,430.63
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	624,408.00
Тэтгэврийн даатгал	624,408.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,986,224.50
Гэрэл, цахилгаан	13,986,224.50
Түлш, халаалт	4,000,000.00
Хангамж, бараа материалын зардал	186,259,956.00
Бичиг хэрэг	17,915,568.00
Тээвэр, шатахуун	154,806,747.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	85,290.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,452,351.00
Нормативт зардал	1,767,465,497.10
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,733,815,497.10
Нормын хувцас, зөөлөн эдлэл	33,650,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	644,840,148.00
Багаж, техник, хэрэгсэл	460,772,648.00
Тавилга	34,615,600.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	44,611,300.00
Урсгал засвар	104,840,600.00
Томилолт, зочны зардал	180,871,410.00
Дотоод албан томилолт	180,871,410.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,827,784,098.48
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,827,774,568.48
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,530.00
Бараа үйлчилгээний бусад зардал	1,356,799,613.00
Бараа үйлчилгээний бусад зардал	1,352,971,613.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,828,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	740,449,762.51
Бусад урсгал шилжүүлэг	74,247,831.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	74,247,831.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	666,201,931.51
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	666,201,931.51
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,940,183,384.00
Дотоод эх үүсвэрээр	2,940,183,384.00
Тоног төхөөрөмж	2,927,196,800.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,986,584.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,793,649,452.22
Нэмэлт санхүүжилтийн орлого	19,793,649,452.22
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,443,725,176.93
ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,256,743,100.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,236,040,695.35
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,857,140,479.94
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-260,480.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	260,480.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Мал эмнэлгийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Д.Түмэндэмбэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн шалгагдагч этгээдэд өгсөн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, үнэт цаасны зарцуулалтад хяналт тавьж ажиллах, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтуудыг баримталж ажиллах, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 05-наас 03 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор Б.Долгоржав гүйцэтгэв.

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/286 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Мал эмнэлгийн ерөнхий газар үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах замаар мал эмнэлгийн салбарыг оновчтой нэгдсэн бодлогоор хангаж, худалдааны чөлөөт байдлыг дэмжихэд оршино” гэж тодорхойлсон байна.

Мал эмнэлгийн газар нь Мал амьтны эрүүл мэндийн тухай, Төрийн албаны тухай хуулиуд болон түүнийг дагалдан гарсан заавар журам, “Төрөөс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын дагуу мал, амьтны болон нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, “Мал эмнэлгийн лаборатори”-ийн хүчин чадлыг сайжруулах, малын өвчин эмгэгтэй тэмцэх, хүн ам, эрүүл мэндийг хамгаалах, хүнсний аюулгүй байдал, худалдааны чөлөөт байдлыг баталгаажуулах зорилтыг хэрэгжүүлэн ажилладаг.

Дээрх үйл ажиллагааны эрхэм зорилгын хүрээнд стратегийн тэргүүлэх чиглэлийг дэвшүүлж ажилласан байна. Үүнд:

1. Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүлжүүлэх бодлогыг оновчтой төлөвлөж, улсын хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангаж хэрэгжилтийг зохион байгуулах;
2. Мал, амьтны шинэ болон дахин сэргэж буй, уур амьсгалын өөрчлөлт, уул уурхайгаас шалтгаалсан өвчин эмгэгийн шалтгаан, нөхцөлийг судалж өвчинтэй тэмцэх арга хэмжээг боловсруулах, судалгаа шинжилгээний үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

3. Өвчингүй тайван бүсийг тогтоож, мал эмнэлгийн олон улсын гэрээ хэлцэл, ариун цэвэр, хорио цээрийн нөхцөлийг тохиролцох, худалдааны чөлөөт байдлыг дэмжих;
4. Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангах, баталгаажуулах замаар нийтийн эрүүл мэндийг хамгаалах;
5. Мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бий болгох, эрт илрүүлэлт, шуурхай хариу арга хэмжээг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх;
6. Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн тогтолцоог бүрдүүлж, бүсчлэн хөгжүүлж, чадавхыг дээшлүүлж, үндэсний болон бүс нутгийн лавлагаа лабораторийн түвшинд хүрэх;
7. Мал, амьтны эмийн үндэсний үйлдвэрлэлийн шинэчлэл хийж олон улсын жишигт нийцүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн үлдэгдлийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, эмийн худалдаа, үйлчилгээний бодлогыг оновчтой тодорхойлж, хэрэгжүүлэх;
8. Мал эмнэлгийн гадаад харилцааг өргөжүүлэх, мал эмнэлгийн салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог хангуулах;
9. Мал эмнэлгийн ажил үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор эрсдэлд суурилсан, мэргэшсэн, чадварлаг мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналтын тогтолцоог бүрдүүлэх;
10. Мал эмнэлгийн салбарын эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах, дотоод, гадаадын сайн туршлагыг нэвтрүүлэх, хариуцлагын тогтолцоог сайжруулах;
11. Мал эмнэлгийн салбар байгууллагуудыг нэгдсэн удирдлагаар хангаж, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрын төрийн захиргааны удирдлагын менежментийг төлөвшүүлж, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, “Иргэн төв төрийн үйлчилгээ”-г нэвтрүүлэх зэрэг болно.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Мал эмнэлгийн ерөнхий газар нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгууллагын Төрийн захиргаа, санхүү, удирдлагын газрын санхүүгийн дотоод аудитор Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Орхон, Ховд, аймгуудын мал эмнэлгийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү нягтлан бодох бүртгэлд илэрсэн зөрчлийг давтахгүй ажиллах, алдаа дутагдлаас урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

Тус газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт орлогыг сонгож, хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт орлого 20,967.1 сая төгрөгөөс 545.3 сая төгрөгөөр тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн

тайлангийн нийт орлого 62,774.7 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 1,255.5 сая төгрөгөөр тогтоолоо.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 0.3 сая төгрөгийг тайлант онд зарцуулж, үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.3	0.0	-0.3
Дүн	0.3	0.0	-0.3

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мал эмнэлгийн ерөнхий газар түүний харьяа байгууллагууд тайлант оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй ажилласан байна.

Аудитын илрүүлэлт:

- Төсвийн хөрөнгөөс 12.7 сая төгрөгийн санхүүгийн анхан шатны бүрдэл дутуу, баримтгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгасан /МЭЭСБУЛ 0.5 сая, Нийслэлийн МЭГ 8.2 сая, Орхон аймгийн МЭГ 0.5 сая, Ховд аймгийн МЭГ 3.5 сая төгрөг/;
- Шүүхийн шийдвэрээр нөхөн олгох төлбөр 19.8 сая төгрөгийг байгууллагын төсвөөс барагдуулсан. /УМЭАЦТЛ 7.3 сая, Говь-Алтай аймгийн МЭГ 9.9 сая, Говьсүмбэр аймгийн МЭГ 2.6 сая төгрөг/;
- Цалин хөлс, ур чадварыг 6.2 сая төгрөгөөр зөрүүтэй бодож олгосон /Сүхбаатар аймгийн МЭГ 1.4 сая, Ховд аймгийн МЭГ 4.8 сая төгрөг/;
- Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад 1.8 сая /Говь-Алтай аймгийн МЭГ 0.2 сая, Завхан аймгийн МЭГ 1.6 сая/, тушаал шийдвэргүй 0.9 сая /МЭЭСБУЛ 0.4 сая, Дархан-Уул аймгийн МЭГ 0.5 сая/ төгрөгийн урамшуулал олгосон;
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас цалингийн зардалд 385.4 сая төгрөгийг олгож зардлын зүйл ангиллыг зөрчсөн /Баянхонгор аймгийн МЭГ 158.8 сая, Говь-Алтай аймгийн МЭГ 67.6 сая, Дархан-Уул аймгийн МЭГ 159.0 сая төгрөг/ байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 3,704.6 сая, эцсийн үлдэгдэл 811.8 сая төгрөг болж, 2,892.8 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны төсвийн хэмнэлтээс үүссэн татаас санхүүжилтийн авлагын 3,000.0 сая төгрөгийг авч зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	4.4	8.6	4.2
Төлбөртэй үйлчилгээний авлага	12.7	44.1	31.4
Татаас, санхүүжилтийн авлага	3,642.7	611.3	-3,031.4
Бусад авлага	44.8	147.8	103.0
Дүн	3,704.6	811.8	-2,892.8

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансанд 1-3 жилийн насжилттай нийт 4.4 сая төгрөгийн үлдэгдэл байгаа бөгөөд 3.0 сая төгрөг нь Нийслэлийн мал эмнэлгийн газрын ажилтнуудтай холбоотой үүссэн авлага байна.

Тайлант онд дараах байгууллагуудын татаас санхүүжилтийн болон байгууллага, хувь хүнээс авах авлага нэмэгдсэн байна. Тухайлбал:

- Мал эмнэлэг, эмийн сорил баталгаажуулалтын улсын лаборатори 44.1 сая төгрөгийн төлбөртэй үйлчилгээний,

- Нийслэлийн МЭГ 13.4 сая төгрөгийн татаас санхүүжилтийн,
- Архангай аймгийн МЭГ 20.0 сая төгрөгийн татаас санхүүжилтийн,
- Өмнөговь аймгийн МЭГ 36.7 сая төгрөгийн татаас санхүүжилтийн,
- Говь-Алтай аймгийн МЭГ 32.5 сая төгрөгийн татаас санхүүжилтийн,
- Завхан аймгийн МЭГ 20.0 сая төгрөгийг байгууллагаас,
- Төв аймгийн МЭГ 20.0 сая төгрөгийг байгууллагаас ,
- Хөвсгөл аймгийн МЭГ 30.0 сая төгрөг байгууллагаас авах авлага байна.

Аудитын илрүүлэлт:

- Хоёр ба түүнээс дээш жилийн насжилттай авлагыг барагдуулаагүй /Нийслэлийн МЭГ 1.9 сая, Архангай аймгийн МЭГ 1.3 сая, Дорноговь аймгийн МЭГ 0.6 сая төгрөг/;
- Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй /МЭЭСБУЛ 2.7 сая, УМЭАЦТЛ -0,7 сая, Нийслэлийн МЭГ 1.9 сая, Завхан аймгийн МЭГ 20.0 сая, Төв аймгийн МЭГ 20.0 сая, Ховд аймгийн МЭГ 9.1 сая төгрөг/;
- Баянхонгор аймгийн МЭГ 2.0 сая төгрөгийн авлагыг бүртгээгүй байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 4.8 сая, эцсийн үлдэгдэл 83.8 сая төгрөг болж, 79.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	4.8	83.8	79.0
Дүн	4.8	83.8	79.0

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансанд Ховд аймгийн МЭГ 55.0 сая, Хэнтий аймгийн МЭГ 28.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийг урьдчилан шилжүүлснийг бүртгэж, тайлагнасан байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 12,567.7 сая, эцсийн үлдэгдэл 10,988.4 сая төгрөг болж, 1,579.3 сая төгрөгөөр буурсан нь бусад хангамжийн материалын зарцуулалттай холбоотой байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	1,915.1	2,004.1	89.0
Эм боох материал	5,563.2	5,603.9	40.7
Бичиг хэргийн материал	86.7	124.4	37.7
Аж ахуйн материал	846.8	755.3	-91.5
Сэлбэг хэрэгсэл	32.1	42.1	10.0
Түлш, шатах тослох материал	61.4	69.8	8.4
Барилгын засварын материал	33.3	32.4	-0.9
Хүнсний материал	0.1	0.1	0.0
Бусад хангамжийн материал	3,988.8	2,271.4	-1,717.4
Мал амьтад	40.2	84.9	44.7
Дүн	12,567.7	10,988.4	-1,579.3

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материал 37,214.0 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн /худалдан авсан 15,853.1 сая, хандиваар 2,862.3 сая, шилжүүлэн авсан 17,959.0 сая, бусад 539.6 сая/, 38,600.5 сая төгрөгөөр буурсан /зарцуулсан 23,884.4 сая, шилжүүлсэн 14,328.8 сая, бусад 387.3 сая/ байна.

Хангамжийн материал 1,693.8 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй ч түүхий эд материалын үлдэгдэл өмнөх оноос 265.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь эм, вакциныг ихээр нөөцөлсөнтэй холбоотой байна. Тухайлбал: УМЭАЦТЛ 2,459.0 сая, Хэнтий аймгийн МЭГ 634.8 сая, Нийслэлийн МЭГ 515.6 сая, Дорнод аймгийн МЭГ 438.6 сая, Архангай аймгийн МЭГ 434.6 сая, Дорноговь аймгийн МЭГ 382.8 сая, Дундговь аймгийн МЭГ 366.4 сая, Ховд аймгийн МЭГ 324.0, Өмнөговь аймгийн МЭГ 295.1 сая, Ховд аймгийн МЭГ 229.4 сая төгрөг гэх мэт.

Аудитын илрүүлэлт:

- Увс аймгийн МЭГ худалдан авах ажиллагааны журамд зааснаар шууд худалдан авах төсөвт өртгийн дээд хязгаарыг зөрчин 17.7 сая төгрөгөөр шатах тослох материалыг бэлтгэсэн;
- УМЭАЦТЛ - 3.2 сая, Нийслэлийн МЭГ 10.2 сая төгрөгийн бараа материалын тоо хэмжээ, нэгжийн үнэ, нэрийг буруу бүртгэсэн, 54.7 сая төгрөгийн бараа материалыг ангиал зөрүүлсэн;
- Баянхонгор аймгийн МЭГ тайлант оны эцэст шатахууны төсвийн хэмнэлтийг төвлөрүүлэлгүй, 2.6 сая төгрөгийн шатахуун нөөцөлсөн, бруцеллёзын вакцин малын тоо толгойноос их байснаас оны эхний үлдэгдэл 4.3 сая төгрөгийн зарцуулагдаагүй хугацаа дуусгасан, ажиллагсад олгосон бараа материалыг бүрэн хөтөлдөггүй, хөрөнгө захиран зарцуулах шийдвэрийг байгууллагын дарга тухай бүрт гаргадаггүй, агуулахын бүртгэлийг хөтлөөгүй;
- Орхон аймгийн МЭГ 2.0 сая төгрөгийн дүрэмт хувцас авч, төсвийг үр ашиггүй зарцуулсан,
- Хэнтий аймгийн МЭГ биетээр хүлээн аваагүй 21.2 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд орлогоор бүртгэсэн;
- Дорноговь аймгийн МЭГ анхан шатны баримтаар нотлогдоогүй бараа материалын 1.3 сая, жолоочийн замын хуудсаар баталгаажаагүй 3.3 сая төгрөгийн шатахуун зарцуулсан нийт 4.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн/

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл цэвэр дүнгээр 18,740.8 сая, эцсийн үлдэгдэл 26,324.4 сая төгрөг болж, 7,583.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

			/сая төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	16,908.6	24,170.1	7,261.5
Барилга, байгууламж, орон сууц	7,420.3	11,997.2	4,576.9
Хуримтлагдсан элэгдэл	-461.7	-756.0	294.3
Авто-тээврийн хэрэгсэл	5,516.3	8,154.1	2,637.8
Хуримтлагдсан элэгдэл	-4,292.2	-4,985.7	693.5
Машин тоног төхөөрөмж	11,092.3	13,246.3	2,154.0
Хуримтлагдсан элэгдэл	-6,709.4	-7,669.4	960.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,653.7	2,282.4	628.7
Хуримтлагдсан элэгдэл	-956.9	-1,095.1	138.2
Бусад үндсэн хөрөнгө	6,942.2	7,885.3	943.1
Хуримтлагдсан элэгдэл	-4,371.0	-4,901.9	530.9
Дуусаагүй барилга	1,075.0	13.0	-1,062.0
Биет бус хөрөнгө	1,832.2	2,154.3	322.1
Программ хангамж	79.2	182.1	102.9
Хуримтлагдсан элэгдэл	-14.7	-35.4	20.7
Бусад биет бус хөрөнгө	1,770.7	2,010.1	239.4
Хуримтлагдсан элэгдэл	-3.0	-2.4	-0.6
Дүн	18,740.8	26,324.4	7,583.6

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгөд тоног төхөөрөмж 29.0, барилга, байгууламж 26.2, тээврийн хэрэгсэл 17.8, бусад үндсэн хөрөнгө 17.2, тавилга, эд хогшил 5.0, бусад биет бус хөрөнгө 4.4, программ хангамж 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 903.8 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 8,177.1 сая, үнэ төлбөргүй хандиваар 2,151.7 сая, бусад 1,632.4 сая, дахин үнэлгээний нэмэгдэл 178.6 сая нийт 13,043.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, балансаас баланст шилжүүлсэн 1,490.8 сая, акталсан 764.5 сая, бусад 13.6 сая, дахин үнэлгээний хорогдол 553.9 сая нийт 2,822.8 сая төгрөгөөр хасагдсан ба тайлант хугацаанд 3,972.1 сая төгрөгийн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн зардал гарсан байна.

Мал эмнэлгийн ерөнхий газар өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлтийн хөрөнгийг зарцуулах зөвшөөрлийг ХХААХҮС-ын 2020 оны А-52 дугаар тушаал, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 405 дугаар тогтоол, МЭЕГ-ын даргын 2019 оны А239 дүгээр тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Нийслэлийн МЭГ 109.5 сая, Дундговь аймгийн МЭГ 88.2 сая, Өмнөговь аймгийн МЭГ 2.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн,
- Баянхонгор аймгийн МЭГ 7.1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй, хувийн мал эмнэлгийн нэгжид 90.1 сая төгрөгийн 38 ширхэг зөврийн компьютер, утасгүй мини хэвлэгчийг хөрөнгөд бүртгэх шийдвэрийг гаргуулаагүй, 47.9 сая төгрөгийн 20 ширхэг мотоциклд улсын бүртгэлийн дугааргүй, 2.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгөд элэгдэл тооцоогүй,
- Дорноговь аймгийн МЭГ үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглагддаггүй 101.9 сая, Дундговь аймгийн МЭГ ашиглагдаж байгаа 24.4 сая төгрөгийн хөрөнгөд дахин үнэлгээ хийгээгүй;
- Төв аймгийн МЭГ хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 20.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээний заалт хэрэгжээгүй;
- Ховд аймгийн МЭГ үндсэн хөрөнгийн тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, өмч хамгаалах комиссын дотоод хяналт сул, бараа материалын дансанд үндсэн хөрөнгүүд бүртгэлтэй, хөрөнгийн бүртгэлийг стандартын дагуу цэгцлээгүй, ОНХС-аас санхүүжигдсэн хөрөнгө оруулалтын 59.7 сая төгрөгийн хэрэгжилт хангалтгүй байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 19.5 сая, эцсийн үлдэгдэл 1,692.3 сая төгрөг болж, 1,672.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	8.1	6.8	-1.3
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.7	15.6	14.9
Байгууллагад төлөх өглөг	9.7	1,655.6	1,645.9
Хувь хүмүүст төлөх өглөг	0.9	14.2	13.3
Дүн	19.5	1,692.3	1,672.8

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт богино хугацаат өр төлбөрийн 97.0 хувийг байгууллагад төлөх, 3.0 хувийг бараа үйлчилгээний зардлын, ажилчидтай холбогдсон, хувь хүмүүст төлөх өглөгүүд эзэлж байна.

Тайлант хугацааны өглөг нэмэгдэхэд гоц халдварт өвчний үйлчилгээний хөлсийг мал эмнэлгийн хувийн үйлчилгээний нэгжид олгоогүй нь голлон нөлөөлсөн бөгөөд нийт өглөгийн 97.5 хувь буюу 1,650.7 сая төгрөгийн өглөг Мал эмнэлгийн ерөнхий газарт, 0.8 хувь буюу 13.0 сая төгрөг нь Нийслэлийн МЭГ-т үүссэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Тайлант онд 19.8 сая төгрөгийн өр үүсгэсэн /МЭЭСБУЛ 0.6 сая, УМЭАЦТЛ 0.4 сая, Нийслэлийн МЭГ 11.1 сая, Дорноговь аймгийн МЭГ 13.5 сая, Дорнод аймгийн МЭГ 1.2 сая, Дундговь аймгийн МЭГ 0.7 сая, Сүхбаатар аймгийн МЭГ 2.9 сая, Ховд аймгийн МЭГ 1.8 сая төгрөг/;

- Нийслэлийн МЭГ 3.7 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, 4.4 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулаагүй /УМЭАЦТЛ 0.7 сая, Ховд аймгийн МЭГ 3.7 сая төгрөг/ байна.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 34,806.0 сая, эцсийн үлдэгдэл 36,516.2 сая төгрөг болж, 1,710.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	9,281.8	9,281.8	0.0
Хуримтлагдсан үр дүн	21,382.7	23,122.8	1,740.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,141.5	4,111.6	-29.9
Дүн	34,806.0	36,516.2	1,710.2

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Орлогын данс

Малын өвчлөл, малын гаралтай бүтээгдэхүүний дээжийг шинжлэх лабораторийн шинжилгээ, малын халдварт өвчний ариутгалыг хийж орлого халдваргүйжүүлэлтээс үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрдүүлдэг байна.

МЭЕГ нь тайлант оны орлого үр дүнгийн тайлангаар нийт 62,774.8 сая төгрөгийн орлогыг тайлагнасан байна.

3.5.9 Зардлын данс

Тайлант онд нийт 60,917.0 сая төгрөгийг зарцуулснаас 11.5 хувь нь цалингийн, 37.5 хувь нь нормативт, 36.6 хувь нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн, 14.4 сая төгрөгийг бусад зардлуудад тус тус зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжаас Говь-Алтай аймгийн МЭГ 67.6 сая, Дархан-Уул аймгийн МЭГ 158.9 сая төгрөгийн цалинг, Орхон аймгийн МЭГ үр дүнгийн урамшууллыг зардал хооронд гүйлгэн зарцуулсан;
- Зардлын эдийн засгийн ангилал зөрүүлэн зориулалт бусаар Дорноговь аймгийн МЭГ 14.3 сая, Өвөрхангай аймгийн МЭГ 1.2 сая, Ховд аймгийн МЭГ 29.7 сая төгрөгийг зарцуулсан;
- Албан томилолтоор ажилласан ажилчдад Сэлэнгэ аймгийн МЭГ 2019 оны баримтаар 0.7 сая, Говь-Алтай аймгийн МЭГ 1.0 сая, Төв аймгийн МЭГ 4.4 сая төгрөгийг илүү олгосон;
- Сахилгын шийтгэлтэй ажилтанд Говь-Алтай аймгийн МЭГ 0.2 сая, Завхан аймгийн МЭГ 1.6 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон;
- Ховд аймгийн МЭГ батлагдсан орон тооноос илүү ажиллуулж төсөв бодит бус төлөвлөгдөн 80.2 сая төгрөгийг зарцуулсан, байгууллагын подваль, узелийг засуулахаар 3.3 сая төгрөгийн гэрээ байгуулсан боловч хүлээн авсан актгүй, хийх ажлын зураг төсөвгүй, ажлын гүйцэтгэлгүй, хугацаандаа хүлээлгэн өгөөгүй, удирдах албан тушаалд сонгон шалгаруулалтгүйгээр мэргэжлийн бус, тэтгэвэрт гарсан хүн ажиллуулж 3.0 сая төгрөгийн үргүй зардал гаргасан, төсөл хөтөлбөрөөс МЭҮН-ийн байр засварыг хүлээлгэн өгөх хугацаа тодорхойгүй, явцын хяналт хийгдээгүй, ажлын даалгавар, зураг төсөв хийгдээгүй, гэрээний гүйцэтгэлгүйгээр 55.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн;
- Нийслэл МЭГ татварын цахим төлбөрийн баримтын системд худалдан авалтын 98.4 сая төгрөгийг бүртгээгүй, 797.2 сая төгрөгийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зарцуулсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг 76,613.2 сая төгрөгөөр тус тус тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн бөгөөд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 29,470.1 сая төгрөгөөр бууруулж 47,143.1 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь өмнөх оны суурь түвшинг баримтлан зардлыг бууруулж баталжээ.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 47,143.1 сая төгрөгийн төсөв батлагдаж, зардлын 46,619.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 523.3 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 43,269.8 сая төгрөгийн санхүүжилтийг авсан ба 3,350.0 сая төгрөгийг Сангийн яам улс орны эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан олгоогүй байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоор 731.5 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 208.2 сая төгрөгөөр давсан нь малын өвчлөл, малын гаралтай бүтээгдэхүүний дээжийг шинжлэх лабораторийн шинжилгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийн орлоготой холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 44,001.3 сая төгрөг буюу 93.3 хувьтай гарсан нь Сангийн яам төсөв тавиагүйгээс малын тарилгын үйлчилгээний хөлсийг мал эмнэлгийн нэгжид шилжүүлээгүй буюу зарцуулаагүй байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаас 1,443.6 сая, Засаг даргын нөөц хөрөнгөөс 6,256.6 сая, дээд шатны төсвийн захирагчаас 7,236.0 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,857.1 сая, нийт 19,793.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэн 19,127.7 сая төгрөгийг зарцуулж 666.2 сая төгрөгийг улсын төсвийн орлогын дансанд татан төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд нийт 99,646.0 сая төгрөгийн 1822 орлого, зарлагын гүйлгээг бүрэн, мэдээлбэл зохих 3675 мэдээллээс 3141 мэдээллийг хугацаанд нь, 496 мэдээллийг хугацаа хоцроож байршуулжээ.

3.8 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 77.5 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн, хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт
/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	77.5	2	65.9	1	11.6	85.0
Нийт	3	77.5	2	65.9	1	11.6	85.0

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 25 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдэн хамрагдснаас аудитаар харьяа 21 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Нийслэл, Ховд аймгийн МЭГ-ын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, Дорноговь аймгийн МЭГ-ын санхүүгийн тайланд “Сөрөг” дүгнэлт өгч, Мал эмнэлгийн ерөнхий газрын санхүүгийн тайланд түүврийн аудитыг гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 9,784.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж 5,197.8 сая төгрөгийн залруулга хийлгэн, 23.2 сая төгрөгийн зөрчилд 18 төлбөрийн акт тогтоож, 1,810.8 сая төгрөгийн 36 зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 2,748.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 69 зөвлөмж өгч, 4.6 сая төгрөгийн зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн байна. Үүнээс Мал эмнэлгийн ерөнхий газрын санхүүгийн тайлангийн аудитаар 1,588.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсний 275.0 сая төгрөгийн алдааг залруулж, 0.9 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэн, 1,313.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүлэн бүртгэсэн байна. Үүнд:

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд УМЭАЦТЛ-ийн төсөвт орлогын 253.7 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтээр, Архангай аймгийн МЭГ төвлөрүүлэх шилжүүлэг 21.3 сая төгрөгийг авлагаар бүртгэснийг залруулсан.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

1. Ариутгал, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын хувцас, багаж хэрэгсэл нийлүүлэх тендерт нэр бүхий компани хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгарч, 249,000,000.00 төгрөгт багтаан нийлүүлэхээр гэрээ байгуулах эрх олгосон боловч МЭТШ /2020/АГ03-007-II гэрээг 249,900,000.00 төгрөгөөр байгуулж санхүүжилт олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-т "Энэ хуулийн 28.4-т заасан нэмж тооцох үнэлгээ нь зөвхөн тендерүүдийг харьцуулах зорилготой бөгөөд тендерийн үнийг өөрчлөх үндэслэл болохгүй", 46 дугаар зүйлийн 46.1.4-т "худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах" заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

2. Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулах 3675 мэдээллээс 496 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

Төвлөрүүлсэн захирагчид 2,719.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 5 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 8,195.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4,922.7 сая төгрөгийн 40 алдааг залруулж, залруулагдаагүй 3,272.6 сая төгрөгийн алдаа зөрчлөөс буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр 23.2 сая төгрөгийн 18 төлбөрийн акт тогтоож, 1,809.9 сая төгрөгийн зөрчилд 34 албан шаардлага хүргүүлж, 1,434.9 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 64 зөвлөмжийг өгч 4.6 сая төгрөгийн зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

"Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 33 дугаар зүйлд зааснаар улсын түвшинд мөрдөгдөх үйлчилгээний нэгдсэн тарифыг өнөөг хүртэл батлагдаагүй байна.

Тайлант оны эцэст вакцины устгалыг нягтлахад малын тоо толгой, статистик мэдээнд үндэслэн вакцинд баримтлах байнгын болон аюулгүйн нөөцийн норм, тоо хэмжээ, хадгалалтын хугацааг зөв тооцож, төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулсан эсэхэд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлнэ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Балансын данстай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт

Тус байгууллагын балансад бүртгэлтэй 2 тээврийн хэрэгслийн эзэмшигчийн гэрчилгээ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар /0818УБИ улсын дугаартай Ланд крузер-200/, 2018 онд татан буугдсан Мал эмнэлгийн үржлийн газрын /7826УБЧ улсын дугаартай Соната-5/ нэр дээр бүртгэлтэй одоог хүртэл шилжүүлээгүй байгаа нь Авто тээврийн тухай хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1-д "Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш нэг сарын дотор аймаг, нийслэл дэх автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллагад бүртгүүлнэ", Зам, тээврийн сайдын 2018 оны 192 дүгээр тушаалаар баталсан "Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын нэгдүгээр хавсралтын 5.1, 5.2, 5.3 дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

4.1.2 Эрсдэл:

Хөрөнгийн ашиглал, шамшигдал үүсэх, холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх;

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Балансад бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийн гэрчилгээнд холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу байгууллагын нэр дээр шилжүүлэн эзэмшигчээр бүртгүүлэх;

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Мал эмнэлгийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 0818 УБИ улсын дугаартай Ланд круйзер-200 маркийн авто машин нь ТӨБЗГ-ын 200-03-31 өдрийн 99 тоот тогтоолоор балансаас балансад шилжин ирснийг үндсэн хөрөнгөд бүртгэж авсан. Эзэмшигчийн бүртгэлийг хийлгэнэ.

4.2 Балансын данстай холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт

Үнэт цаасыг хариуцсан мэргэжилтний хариуцлагагүй байдал, зарцуулалтад тавих хяналт сул байгаагаас шалтгаалан 550 төгрөгийн нэг бүрийн үнэ бүхий 1065 ширхэг нийт 0.6 сая төгрөгийн импорт, экспортын гэрчилгээ, лиценз урд оны тэмдэглэгээтэй, давхардаж дугаарласан, буруу бичсэн зэргээс хүчингүй болсон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

4.2.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үнэгүйдүүлэх, үр ашиггүй зарцуулах, дотоод хяналт алдагдах, холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх;

4.2.3 Өгсөн зөвлөмж:

Бараа материал, хөрөнгийг үр ашигтай зарцуулах, үнэт цаасны зарцуулалтад хяналт тавьж ажиллах, дотоод хяналтыг сайжруулах;

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үнэт цаас хариуцсан мэргэжилтэн сар бүр МЭЭАБГ-ын даргаар баталгаажуулан тайланг гарган санхүүтэй тооцоо хийж хэвшүүлнэ.

4.3. Худалдан авалт, гэрээний хэрэгжилтийн талаар

4.3.1 Илрүүлэлт

Худалдан авах ажиллагааг шалгах явцад тендерт шалгарсан 7 компанид гэрээ байгуулах мэдэгдлийг төсөв захирагч бус үнэлгээний хорооны дарга хүргүүлсэн, 4 компанитай үнэлгээний хорооны мэдэгдэл хүргүүлснээс хойш ажлын 5-6 дахь өдөрт ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан, 6 компанийн гэрээний хэрэгжилтийг 2- 40 хоногоор хэтрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2, 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтуудыг зөрчиж байна.

4.3.2 Эрсдэл:

Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж ажиллаагүйгээс шамшигдал болон ашиг сонирхол үүсэх;

4.3.3 Өгсөн зөвлөмж:

Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, гэрээний үүргийг хэрэгжүүлэх, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах;

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үнэлгээний хороо захиалагчид мэдэгдэл хүргүүлснээр захиалагч гэрээ байгуулах эрх олгох тухай тушаал гаргахдаа Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах газрын даргад гэрээ байгуулж ажиллахыг даалгаснаар мэдэгдлийг хүргүүлж ажилласан.

4.4. Зардлын данстай холбоотой асуудал

4.4.1 Илрүүлэлт

ХХААХҮС-ын 2020 оны А-51 тушаалаар биобэлдмэл худалдан авах төсвийг зарлагын эдийн засгийн ангилал зөрүүлэн төсөвлөж 1,313.5 сая төгрөгийн вакциныг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж буюу зориулалт зөрчин зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9 “Энэ хуулийн 22.6.8-д заасан ангиллаар тогтоосон төсвийг зүйл хооронд шилжүүлэн зарцуулах эрхийг төсвийн захирагчийн ангилал бүрээр тогтоох, томсгосон хяналтын түвшинг тогтоох нийтлэг журмыг Засгийн газар тогтоон мөрдүүлнэ”, 42 дугаар зүйлийн Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх хязгаар, нөхцөл, журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.1, 3.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

4.4.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг зориулалт бус, хэмнэлтгүй зарцуулах

4.4.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах;

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

ХХААХҮС-ын 2020-02-07 А-51 тушаалаар Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийг задаргааны төлөвлөгөөг батлуулан захиран зарцуулсан болно.

4.5. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

4.5.1 Илрүүлэлт

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар эд хөрөнгийн тооллого хийгээгүй, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, цалин урамшууллыг буруу тооцож олгосон, авлага, өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн, холбогдох хууль, тогтоомж, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй нийт

7,435.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн, Нийслэл, Ховд аймгийн МЭГ-ын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, Дорноговь аймгийн МЭГ-ын санхүүгийн тайланд “Сөрөг” дүгнэлт өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, 16.5.6-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

4.5.2 Эрсдэл:

Төсвийг үр ашиггүй үрэлгэн зарцуулах, дотоод хяналт, төсвийн сахилга бат алдагдах;

4.5.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах;

4.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Харьяа байгууллагуудын төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг нэгтгэсэн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	3	4	5	6	7
ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ					
1. МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН					
1	"Ариутгал, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын хувцас, багаж хэрэгсэл нийлүүлэх тендерт "Бэст агро интернейшнл ХХК" хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгарч, 249,000,000.00 төгрөгт багтаан нийлүүлэхээр гэрээ байгуулах эрх олгосон боловч МЭТШ/2020/АГ03-007-II гэрээг 249,900,000.00 төгрөгөөр байгуулж санхүүжилт олгосон байна.	0.9	Албан шаардлага хүргүүлэх	МАЭМХГ-ын Мэргэжилтэн	С.Ганзориг
	Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулах 3675 мэдээллээс 534 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан		Албан шаардлага хүргүүлэх	ХХААХҮЯ-ны мэргэжилтэн	Д. Чинбат
	Тус байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын нэр дээр бүртгэлтэй 0818УБИ улсын дугаартай Ланд крузер-200, татан буугдсан Мал эмнэлгийн үржлийн газрын нэр дээр бүртгэлтэй 7826УБЧ улсын дугаартай Соната-5 тээврийн хэрэгслийн эзэмшигчийн нэрийг одоог хүртэл шилжүүлээгүй байна.		Зөвлөмж өгөх	СХОГ-ын дарга Нягтлан бодогч	Л.Гандолгор М.Солонго
2	Бараа материалын зарцуулалтаас үнэт цаасыг хариуцсан мэргэжилтний хариуцлагагүй байдал, зарцуулалтад тавих хяналт сул байгаагаас шалтгаалан 550 төгрөгийн нэг бүрийн үнэ бүхий 1065 ширхэг нийт 0.6 сая төгрөгийн импорт, экспортын гэрчилгээ, лиценз урд оны тэмдэглэгээтэй, давхардаж дугаарласан, буруу бичсэн зэргээс хүчингүй болсон байна.	0.6	Зөвлөмж өгөх	МЭЭАБГ-ын дарга Нягтлан бодогч	Б.Болдбаатар М.Солонго
3	Худалдан авах ажиллагаанд шалгарсан 7 компанид гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг төсөв захирагч бус үнэлгээний хорооны дарга хүргүүлсэн, үнэлгээний хорооны мэдэгдэл хүргүүлснээс хойш ажлын 5-6 дахь өдөрт 4 компанитай ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан, 6 компани ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилтийг 2-40 хоногоор хэтрүүлсэн байна.		Зөвлөмж өгөх	МАЭМХГ-ын дарга СХОГ-ын ахлах мэргэжилтэн	Б.Тунгалаг С.Мягмаржав
4	ХХААХҮСайдын 2020 оны А-51 тушаалаар биобэлдмэл худалдан авах төсвийг зарлагын эдийн засгийн ангилал зөрүүлэн төсөвлөж 1,313.5 сая төгрөгийн вакциныг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж буюу зориулалт бус зардлаас зарцуулсан байна.	1,313.5	Зөвлөмж өгөх	Дарга СХОГ-ын дарга	Д.Түмэндэмбэрэл Л.Гандолгор
5	Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар эд хөрөнгийн тооллого хийгээгүй, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, цалин урамшууллыг буруу тооцож олгосон, авлага, өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн зэрэг нийт 7,435.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн, Нийслэл, Ховд аймгийн МЭГ-ын санхүүгийн тайланд "Хязгаарлалттай", Дорноговь аймгийн МЭГ-ын санхүүгийн тайланд "Сөрөг" дүгнэлт өгсөн.	1,404.3	Зөвлөмж өгөх	Дарга СХОГ-ын дарга	Д.Түмэндэмбэрэл Л.Гандолгор
НИЙТ ДҮН		2,719.3			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25 № 470/АО170070
САН 2021/18/СТА ТТЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мал эмнэлгийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ариутгал, халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын хувцас, багаж хэрэгсэл нийлүүлэх тендерт нэр бүхий компани хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгарч, 249,000,000.00 төгрөгт багтаан нийлүүлэхээр гэрээ байгуулах эрх олгосон боловч МЭТШ/2020/АГО3-007-II гэрээг 249,900,000.00 төгрөгөөр байгуулж санхүүжилт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-т "Энэ хуулийн 28.4-т заасан нэмж тооцох үнэлгээ нь зөвхөн тендерүүдийг харьцуулах зорилготой бөгөөд тендерийн үнийг өөрчлөх үндэслэл болохгүй", 46 дугаар зүйлийн 46.1.4-т "худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах" заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үнэлгээний хороо болон Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын шийдвэрт заасан үнийн дүнгээр гэрээ байгуулж, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Д.Түмэндэмбэрэл, Санхүү, хөрөнгө оруулалтын дарга Л.Гандолгор нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Я.САМБУУНЯМ
Б.ДОЛГОРЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25

№ 471/АД/2020

Улаанбаатар хот

СМТ 2021/18/СТА-773

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мал эмнэлгийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулах 3675 мэдээллээс 496 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж мэдээллийн ил тод байдлыг хангах, хуулийн хугацаанд иж бүрэн мэдээллийг байршуулах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Д.Түмэндэмбэрэл, Санхүү, хөрөнгө оруулалтын дарга Л.Гандолгор нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

АУДИТОР

Б.ДОЛГОРЖАВ

[illegible]